

## ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

**Е. В. БОЙКОВА, ОТНОШЕНИЯ МНР С  
КАПИТАЛИСТИЧЕСКИМИ И РАЗВИВАЮЩИМИСЯ  
СТРАНАМИ, 60—70-Е ГОДЫ, МОСКВА. 1972**

Зөвлөлтийн монголч эрдэмтэн Е. В. Бойковагийн бичсэн энэ номд БНМАУ ба ЗХУ зэрэг социалист хамтын нөхөрлөлийн орнуудын найрамдал, хамтын ажиллагаа өргөжин хөгжөөд «гуравдагч» ертөнц ба хөрөнгөтөн орнуудтай дипломат харилцаа тогтоосны эхний үеийн тухай өгүүлж байна. Зохиогч их хэмжээний баримт материалд түшиглэн судалгаа хийж БНМАУ-ын гадаад бодлогын хөгжилт, олон улсын байгууллага дахь түүний үйл ажиллагаанд шинжлэх ухааны үндэстэй үнэлэгээ өгсөн байна. Тус номын утга агуулга, хөндсөн асуудлууд нь номын нэрээс өргөн хүрээтэй болсныг тэмдэглэх хэрэгтэй. Зохиогч зөвхөн хөгжиж байгаа ба хөрөнгөтөн орнуудтай БНМАУ-ын тогтоосон харилцааг судлаад зогсохгүй, Азийн энх тайван, аюулгүй байдлыг хангахын төлөө БНМАУ-аас гаргаж буй хүчин чармайлт, НҮБ болоод түүний тусгай байгууллага, засгийн газрын бус олон улсын байгууллага дахь манай улсын үйл ажиллагааг задлан шинжилж бичжээ.

Уг номын оршил хэсэгт нь зохиогч Ардын хувьсгал ялсан 1921 оноос эхлэн БНМАУ-ын гадаад бодлогыг тоймлон үзүүлжээ. Үүнд БНМАУ-ын гадаад бодлогыг дайны өмнөх ба дайны дараах гэсэн 2 үндсэн шат болгон хувааж, дайны дараах шатаа 1945—1961 он, 1961-ээс одоо хүртлэх үе гэж хувааж үзсэн байна. (4-р тал) Ингэж хуваасан нь санамсаргүй хэрэг бишээ.

Дэлхийн II дайн дуусч, дэлхийн социалист систем бүрэлдэн тогтсон явдал БНМАУ-ын олон улсын харилцааны хөгжилд шинэ үеийг нээсэн юм. Тэгш эрхийн зарчим, харилцан итгэлцэх, шинэ нийгмийг байгуулах гэсэн эрхэм дээд зорилгод хүрэх ижил ашиг сонирхлын үндсэн дээр хэрэгжиж байгаа олон улсын харилцааны шинэ хэлбэр болсон социалист орнуудтай харилцах харилцааг юуны түрүүнд тэмдэглэх хэрэгтэй.

БНМАУ хөрөнгөтөн орнуудтай харилцах харилцаандаа энх тайвнаар зэрэгцэн орших, дотоод хэрэгт үл оролцох, тусгаар тогтнолоо харилцан хүндэтгэх зарчмуудыг хатуу баримталж байдаг. Энэ бол БНМАУ-ын улс төрийн бодлогын тактикийн алхам биш, харин социалист төрийн гадаад бодлогын ленинч зарчмыг баримталсан стратегийн шинж чанартай гадаад улс төрийн чиг шугам юм. (19-р тал).

Улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаа нь энх тайвнаар зэрэгцэн орших материаллаг үндэс болдог. БНМАУ эрх тэгш харилцан ашигтай байдлын үндсэн дээр капиталист орнуудтай гадаад худалдаагаа хөгжүүлэх нь гадаад худалдааны байнгын өсөлт, үндэсний эдийн засгийг бэхжүүлэх төдийгүй, орчин үеийн олон улсын харилцааг намжаан зөөлрүүлэхэд чухал гэж үздэг юм. (22-р тал).

60-аад оноос эхлэн БНМАУ хөрөнгөтөн орнуудын гадаад худалдааны 200 гаруй пүүс, байгууллагатай худалдааны харилцаа тогтоожээ. Харин өрнөдийн гүрнүүдтэй дипломат харилцаа тогтооход

БНМАУ 1961 онд НҮБ-д гишүүнээр элссэн явдал ихээхэн нөлөөлснийг дурдах хэрэгтэй юм. Зохиогч БНМАУ, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох асуудлыг ч хөндөж нэлээд тодорхой баримт сэлт оруулсан байна.

АНУ болон Тайваний засгийн газар БНМАУ-ыг НҮБ-ын гишүүн болгох тухай асуудал хэлэлцэхэд шууд татгалзаж байсан юм. Үүний зэрэгцээ БНМАУ-ыг АНУ биеэ даасан тусгаар тогтносон улс гэхэд «эргэлзээтэй» хэмээн албан ёсоор хүлээн зөвшөөрөхийг хүсдэггүй байв. ЗХУ болоод социалист бусад орнуудын шийдвэртэй үйл ажиллагаа БНМАУ-ыг ялгаварлан гадуурхах явдлыг зогсоосон юм. Үүний үр дүнд манай орон 1961 оноос эхлэн НҮБ-ын хууль ёсны гишүүн болсон билээ.

70-аад онд манай улс ардын аж ахуйд олсон ололт амжилт нь гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, экспорт, импортын бүтэцийг нэлээд өөрчлөхийн зэрэгцээ (27-р тал) энэ үед Австри, Финлянд зэрэг хэд хэдэн хөрөнгөтөн оронтой худалдааны урт хугацаатай хэлэлцээр байгуулсан нь ганц нэг удаагийн худалдаа наймааг бодвол хэн хэндээ илүү ашигтай тухай Е. Бойкава бүтээлдээ зөв зүйтэй дурджээ.

Уг номын II бүлэгт БНМАУ Ази, Африкийн хөгжиж байгаа орнуудын харилцааны тухай өгүүлж байна. Монгол ба хөгжиж байгаа орнуудын харилцаа зөвхөн БНМАУ-ын хувьд төдийгүй социалист нөхөрлөлийн орнуудын хувьд ч чухал ач холбогдолтой гэдгийг зохиогч онцлон заасан байна. (54-р тал). Өнгөрсөн үед Азийн хоцрогдсон орны нэг байсан Монгол түүхийн харьцангуй богино хугацаанд нийгэм, эдийн засаг, соёлын том амжилтанд хүрсэн бодит жишээ нь хөгжиж байгаа орнуудад нөлөө үзүүлээд зогсохгүй тэдний дэвшил хөгжлийн замыг сонгож авахад нь тус болж байна.

Хөгжиж байгаа олон орнуудын колоничлол, шинэ колоничлолын эсрэг, энх тайван аюулгүй байдал, эдийн засгийн шинэ дэг журам тогтоохын төлөө нэгдсэн зорилготой тэмцэл нь БНМАУ-тай найрамдлын харилцаа хөгжүүлэх бодит үндэс болж байгаа юм. Гэвч зарим объектив шалтгаанаас (тэдгээрийн газар зүйн хувьд алслагдсан байдал, хоёр талын экспорт импортын ижил маягийн бүтэц) болж эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхтэй хөгжүүлэх нөхцөл бага учраас хөгжиж байгаа орон БНМАУ-ын хоорондын хамтын ажиллагаа нь улс төр, соёлын чиглэлээр голчлон явагдаж байгааг зохиогч зөв дүгнэжээ.

БНМАУ Ази, Африкийн шинэ залуу орнуудтай холбоо харилцаа хөгжүүлэхэд эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд асар их үүрэг гүйцэтгэдэг азийн томоохон гүрний нэг Энэтхэгтэй албан ёсны дипломат харилцаа тогтоосон нь чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Мөн номд Бирм, Балба, Гвиней, Мали болон бусад Ази, Африкийн орнуудтай Монголын тогтоосон дипломат харилцааны түүхийг өгүүлжээ.

Ази тивд энх тайван, аюулгүй байдлыг хангахын төлөө БНМАУ ын тэмцэл, социалист чиг баримжаат орнуудын хөгжилд тус улсын капиталист биш хөгжлийн түүхэн туршлага ямар ач холбогдолтой талаар өгүүлсэн номын хэсэг ихээхэн сонирхол татаж байна.

Монголын капиталист биш хөгжлийн түүхэн туршлага гадаад дотоод өвөрмөц онцлогтой боловч социалист чиг баримжаат орнуудад хэрэглэж болох онол практикийн ач холбогдолтой бөгөөд БНМАУ-ын туршлага нь юуны түрүүнд, хоцрогдсон ард түмнүүдийн хөгжлийн замын тухай заасан марксист-ленинист сургаалыг бодит амьдралд баталж өгсөнд түүний ач холбогдол нь оршиж байгааг зохиогч дурдаад капиталист биш хөгжлийн замыг үгүйсгэх буюу үүний эсрэг тэмцэх

нь орчин үеийн коммунизмын эсрэг үзлийн бүрэлдэхүүн хэсэг мөн гэжээ. (92, 94-р тал)

Азийн аюулгүй байдал, олон улсын байдлыг эрүүлжүүлэх өнөө үеийн тулгамдсан асуудлууд МАХН, БНМАУ-ын засгийн газрын анхаарлын төвд ямагт байдаг. Энхийг эрхэмлэгч нийт хүчний нэгэн адил БНМАУ, Ази тивийг дэлхийн социализмын эсрэг түшиц газар болгох, Номхон далайд зэвсгээр хөөцөлдөх, дайн түгшүүртэй байдлын голомтыг дэвэргэхийг оролдож байгаа империалист, харгис хүчний эсрэг шийдвэртэй тэмцэл явуулж байна. БНМАУ-аас энэ талаар хийсэн бодитой алхмууд үүнийг баттай нотолж өгнө. Монголын ард түмэн, БНХАУ-ын Засгийн газар дайныг сэрэмжлэн зайлуулах, манай гаригийн ард түмэн энх амгалан амьдарч, хөдөлмөрлөхийг заасан энх тайвны зорилгод нийцсэн ямар ч саналыг бүрэн дүүрэн дэмждэг юм.

Азийн энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэх нь Европт, төдийгүй бүх дэлхийн энх тайвны төлөө тэмцэлтэй салшгүй холбоотой гэж БНМАУ үзэж байна. Азийн энх тайван, тогтвортой байдлын төлөө БНМАУ-аас явуулж буй тэмцэл түгшүүртэй байдлыг намжаахын төлөө социалист орнуудын нийтийн тэмцэлд зохих хувь нэмэр оруулж байна.

БНМАУ-ын гадаад бодлогын нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг нь олон улсын янз бүрийн байгууллага дахь түүний үйл ажиллагаагаар илэрч байдаг. Олон улсын томоохон хурал, зөвлөлгөөнд оролцохдоо БНМАУ өөрийн үйл ажиллагааг хүн төрөлхтний тулгамдсан асуудал, тухайлбал зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, бат бэх энх тайван, аюулгүй байдлыг тогтооход чиглүүлж ирлээ. НҮБ болон түүний тусгай байгууллагын ажилд социалист орны хувьд Монголоос оруулж байгаа хувь нэмэр болон дэс дараатай үйл ажиллагааны тухай тус номын эцсийн 3-р бүлэгт өгүүлсэн байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган болон түүний хороонуудад БНМАУ энх тайвны төлөө зэвсэг хураах чиг шугамыг тууштай баримтлагч болохоо нотлон харуулсан юм. БНМАУ социалист орнуудын хамт зэвсэг хураах асуудал хэлэлцсэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулганыг бэлтгэн явуулахад идэвхтэй оролцож ирэв. НҮБ-ыг үндэслэн байгуулсан өдөр жил бүрийн 10-р сарын 24-нийг зэвсэг хураах зорилгод дэмжлэг үзүүлэх Олон улсын 7 хоног болгон зохион явуулж байхаар БНМАУ-ын санаачлагаар НҮБ-ын тусгай чуулган 1978 онд шийдвэрлэсэн юм.

Дэлхий дахинд энх тайван тогтоох, социалист хамтын нөхөрлөлийн орнууд, олон улсын пролетари, үндэсний эрх чөлөө, нийгмийн дэвшилт хүчний нийгэм-ангийн ашиг сонирхлыг хамгаалахын төлөө монголын ард түмний явуулж байгаа интернационал тэмцэл нь улс түмний аюулгүй байдал, энх тайвны төлөө нийтийн тэмцэлд зохих хувь нэмэр оруулж байна. (117-р тал)

Олон улсын тулгамдсан чухал асуудлыг шийдвэрлэхэд БНМАУ социалист бусад орнуудтай зохицуулсан байр суурь баримталж, өөрийн интернационалч үүргээ тууштай хэрэгжүүлж, энх тайвныг хамгаалахын төлөө шийдвэртэй тэмцэж байгаа нь түүний олон улсын байр суурийг бэхжүүлж улмаар дэлхийн социализмын хүчийг бататгах нэгэн хүчин зүйл болж байна. (163-р тал)

Тусгаар тогтносон социалист Монголын улс хоорондын харилцааны чухал үеийг хамарч бичсэн Е. В. Бойковагийн энэ ном БНМАУ-ын өнөө үеийн гадаад бодлогыг сонирхогч, судлагч бүх уншигчдад сонирхол татахуйц өндөр ач холбогдолтой болжээ.

**Г. Зориг**